ГЕРМЕС ЦЕНТР
ХУВЬЦААТ КОМПАНИ

# НЭМЖ ГАРГАЖ БУЙ ХУВЬЦААНЫ ТАНИЛЦУУЛГА

УЛААНБААТАР
2008

# АГУУЛГА

Хувьцааны тухай мэдээлэл ....................................................2

Стратеги .................................................................................3

Төслийн үндэслэл .....................................................................4

Дотоод худалдааны зах зээлийн судалгаа ..............................5

SWOT шинжилгээ ......................................................................6

Компанийн танилцуулга ...........................................................7

Бизнесийн түнш.........................................................................8

Санхүүгийн үзүүлэлтүүд ...........................................................9

Хувь нийлүүлэгчдийн танилцуулга .........................................10

Компанийн бүтэц зохион байгуулалт .....................................11

Санхүүгийн таамаглал .............................................................12

Ашгийн таамаглал ....................................................................12

Хувьцааны зах зээлийн үнийн таамаглал ..............................13

Ноогдол ашиг хуваарилах бодлого .........................................13

Батс инвест ХХК .......................................................................14

# ХУВЬЦААНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргах тухай Санхүүгийн Зохицуулах Хорооны тогтоол: | 99-р тогтоол |
| Үнэт цаас гаргачийн нэр: | "Гермес Центер" ХК |
| Хаяг: | Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4-р хороо, 2-р хороолол, Өөрийн байр |
| Үнэт цаасны нэр: | "Гермес" хувьцаа |
| Хувьцааны төрөл: | Энгийн хувьцаа |
| Нэрлэсэн үнэ: | 100 төгрөг |
| Нийт хувьцаа: | 78 543 001 |
| Үүнээс анхдагч зах зээлд нийлүүлэх | 23 562 900 |
| Олон нийтэд санал болгож буй хувьцааны нийт энгийн хувьцаанд эзлэх хувь | 30% |
| Хувьцааг арилжаалах байгууллага: | Монголын Хөрөнгийн Бирж |
| Хувьцаагаар хуримтлуулах хөрөнгийн зориулалт : | Эрдэнэт хотод салбар худалдааны төвийг байгуулах |
| Ерөнхий зуучлан борлуулагч: | "Батс-Инвест" Андеррайтер брокер, дилерийн компани |
| Хаяг: | Монгол улс, Улаанбаатар хот, СБД, Ерөнхий сайд Амарын гудамж, Үнэн сонины байр, 2 давхар, 201, 202 тоот |
| Утас: | 976-11-321899 |
| E-mail: | broker@batsinvest.mn<br>info@batsinvest.mn |

# СТРАТЕГИУД

**Богино хугацааны стратеги (2008 он)**

- Улаанбаатар хот дахь Гермес худалдааны төвийн маркетингийг идэвхжүүлэх, нэгж талбайгаас орох түрээсийн орлогыг 35 хувиар нэмэгдүүлэх.
- Орхон аймгийн Эрдэнэт хотод салбар худалдааны төв байгуулах.

**Дунд хугацааны стратеги (2009-2010 он)**

- Дархан Уул , Сэлэнгэ зэрэг аймгуудад салбар худалдааны төв байгуулах.
- БНХАУ-ын нэр хүнд бүхий барилгын материал үйлдвэрлэгч компаниудтай хамтарч Гермес худалдааны сүлжээгээр үйлдвэрлэгчийн үнээр бараа бүтээгдэхүүн борлуулах системд шилжинэ.
- БНХАУ-ын Дади авто компанитай байгуулсан албан ёсны онцгой эрхт төлөөлөгчийн гэрээний хүрээнд орон нутагт Pick-up буюу бага оврын ачаатай жип автомашины худалдаа, засвар үйлчилгээний төвийг байгуулах.
- “Гермес Ачаа Тээвэр” салбар компанийн үйл ажиллагааг эхлүүлнэ. Тянжин, Бээжин, Эрээн, Замын Үүд, Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Сэлэнгэ зэрэг маршрутад 40, 60 тонны хөлдөөгч хөргөлттэй болон хөргөлтгүй чингэлэгт автотээврийн бизнесийг худалдааны төвийн сүлжээг түшиглэн хэрэгжүүлнэ.

**Урт хугацааны стратеги (2009-2010 он)**

- “Гермес Лизинг” салбар компанийн үйл ажиллагааг хөгжүүлнэ.
- “Гермес Ачаа Тээвэр” салбар компанийн үйл ажиллагааг хөгжүүлнэ.
- Орон нутагт салбар худалдааны төвүүдийг томруулна. Сэлэнгийн чөлөөт худалдааны бүсэд худалдааны төв барина.

# ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

"Гермес Центер" худалдааны төв нь орон нутагт салбар худалдааны төвүүдийг байгуулж, худалдааны сүлжээг хөгжүүлэх зорилго тавьж ажиллаж байгаа. Энэ үүднээс 2008 онд нэмж хувьцаа гарган 2 354 000 000 төгрөгийг хуримтлуулснаар дараахь төслийг хэрэгжүүлнэ.

**Санхүүжүүлэх төсөл № 1.**
Застийн газрын "40000 орон сууц" хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэт хотод баригдах орон сууцны 7-р хороололд Гермес Худалдааны төвийг барьж ашиглалтанд оруулах
Санхүүжүүлэх төслийн төсөвт өртөг: 2,400, 000,00.00 төгрөг
Эрдэнэт хот дахь Худалдааны төвийн барилгыг барьж дуусгах хугацаа : 2008 оны 12 сар

**Байршил**
"Гермес худалдааны төв"-ийг Застийн газрын "4000 орон сууц" хөтөлбөрийн хүрээнд Эрдэнэт хотын ерөнхий төлөвлөгөө, Орхон аймгийн газар зохион зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 2007 оны 05-р сарын 07-оос хэрэгжиж эхэлсэн 2500 айлын орон сууц бүхий Эрдэнэт хотын орон сууцны 7-р хорооллын нутаг дэвсгэрт байгуулна.

**Газар**
Орхон аймаг дахь Эрдэнэт хотын "Гермес худалдааны төв"ийн барилга байгууламжийг нийт 2000 шоо метр талбай бүхий газар дээр Барилга Хот Байгуулалтын Яамнаас барилга угсралтын БУ12-00035/07 тоот тусгай зөвшөөрөлтэй, Орхон аймгаас орон сууцны 7-р хороолол барих зөвшөөрөл авсан 0002600 тоот газрын гэрчилгээтэй бөгөөд Барилга Хот Байгуулалтын Яамны 0065/07тоот батламж бүхий "4000 орон сууц хөтөлбөрт оролцогч"-оор бүртгэгдсэн "Хуанлу Хуанпун" ХХК-тай 2008 оны 2-р сарын 12-ний өдөр байгуулсан 05 тоот Барилгын ажлыг гүйцэтгэж хамтран ажиллах гэрээний дагуу барина.

**Эрдэнэт худалдааны төвийн ерөнхий зураг**




Эрдэнэт хотод салбар худалдааны төвийг байгуулснаар 2008 оны 4 дүгээр улиралд "Гермес Центр" компанийн түрээсийн орлого 2007 оныхоос даруй нэг дахин нэмэгдэж, цэвэр ашиг мөн ижил хэмжээгээр өснө.

**Төсөвлөгдөж буй орлого эдийн засгийн үр дүн**
*Одоогийн Улаанбаатар хот дахь Гермес худалдааны төвийн орлого:*

| | |
|---|---|
| Борлуулалтын орлого (жилд) | 780.0 сая төгрөг |
| Цэвэр ашиг (борлуулалтын 35%) | 273.0 сая төгрөг |

*Төслийн санхүүжилтээр баригдах Орхон аймгийн Эрдэнэт Хотноо, Орон сууцны 7-р хороололд баригдах "Гермес Худалдааны Төв"-ийн төсөвлөгдсөн орлого:*

| | |
|---|---|
| Нийт талбай нийт ашигтай түрээслүүлэх | 3600 м.кв талбай (Эрдэнэт хот. Нийт 80 000 хүн амтай ) |
| Түрээслэх сарын үнэ нэгж м.кв талбайд | 8000 төгрөг |
| Нийт орлого (жилд) | 345.6 сая төгрөг |
| Цэвэр Ашиг (орлогын 35 хувь) | 121.0 сая төгрөг |

*Санхүүжилтийн төсөл № 1 хэрэгжсэнээр Гермесцентр ХК-ийн төсөвлөгдсөн бүгд орлого:*

| | |
|---|---|
| Борлуулалтын орлого (жилд) | 1 125.6 сая төгрөг |
| Бүгд цэвэр ашиг (жилд) | 394. 0 сая төгрөг |

# ДОТООД ХУДАЛДААНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

Монгол улс 2.6 сая (суурин хүн) хүнтэй. Нийт хүн амын 60.9% буюу 1.6 сая хүн хот суурин газар амьдардаг бөгөөд 70 мянган оршин суугчтай аймаг 2 (Эрдэнэт, Дархан), 994.8 оршин суугчтай хот нэг (Улаанбаатар хот) байна. Эндээс Эрдэнэт болон Дархан хотууд нь хүн амынхаа төвлөрлөөрөө Улаанбаатар хотын дараа орж байна.

Хүн амын хурдацтай өсөлт болон хэт төвлөрлөөс үүдэн бөөний болон жижиглэн худалдааны салбар жил ирэх тусам өргөжиж байна. Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт 2007 оны байдлаар 814.3 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд энэ нь өмнөх оноосоо 42.9 % буюу 244.6 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.

ДНБ-ийн тал хувийг бий болгож байгаа Орхон аймгийн хүн ам болон амжиргааны төвшин жил ирэх тусам өсч байгаа бөгөөд энэ ч үүднээсээ энэхүү аймагт худалдаа үйлчилгээний салбар бусад салбартай харьцуулахад өргөжиж байна. 2007 оны байдлаар аймгийн худалдаа нийтийн хоолын салбар 782 цэг салбар 9.7 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийсэн нь өмнөх оноосоо 9.8%-аар өссөн. Аймгийн хүн ам 2004 оноос дунджаар 0,99%-аар өсөхөд, худалдаа үйлчилгээний салбарын орлого 24,2%-аар, нийтийн хоолны салбарын орлого 17%-аар өсч байсан байна.

**Орхон аймгийн Худалдаа үйлчилгээний байгууллагын тоо;**

| Үзүүлэлтүүд | 2004 | 2005 | 2006 | 2007 |
|---|---|---|---|---|
| Барааны дэлгүүр | 42 | 64 | 73 | 70 |
| Хүнсний дэлгүүр | 220 | 230 | 273 | 298 |
| Үйнээс согтууруулах ундааны гүйлгээ | 146 | 167 | 209 | 220 |
| Авто сэлбэгийн дэлгүүр | 14 | 18 | 19 | 14 |
| Барилгын дэлгүүр | 15 | 10 | 12 | 10 |
| Нийт | 437 | 489 | 586 | 612 |

# SWOT шинжилгээ

**Давуу тал:**

· Бизнесийн салбарын багц сайн; Түрээс, Цахилгаан барааны лизинг худалдаа, автомашины лизинг засвар үйлчилгээ.

· Гадаад ба дотоодын нэр хүнд бүхий байгууллагуудтай хамтран ажиллах гэрээгээр үйл ажиллагаагаа баталгаажуулсан.

· Мөнгөн урсгал сайн, Өрийн харьцаа бага болон Ашигт ажиллагаа өндөр.

· Хөдөө орон нутагт байгаа салбаруудын нэр хүнд сайн. Салбар сүлжээгээ нэмж өргөжүүлнэ.

· Банк болон даатгалын байгууллагуудтай хамтран лизингийн борлуулалт, эд хөрөнгийн даатгал зэргийг хамтран шийдсэнээр санхүүгийн дэд бүтцийг байгуулсан.

· Худалдаалж буй гэр ахуйн цахилгаан бараа болон автомашин зэргийн чанар үйлчилгээ сайн бөгөөд үнэ бусад өрсөлдөгч байгууллагаас хямд.

**Сул тал:**

· Салбар сүлжээг хангалттай тоогоор хөгжүүлээгүй. Борлуулж буй бараа бүтээгдэхүүний хувьд үйлдвэрлэгчийн чанарын доголдол гардаг. Компани өөрсдийн цахилгаан барааны засвар үйлчилгээний хэлтсийг байгуулах шаардлагатай.

**Боломж:**

· 2008 онд Орхон аймагт нэмж худалдааны салбар төв барина. Салбар сүлжээг хөгжүүлнэ.

**Аюул:**

· Салбар сүлжээ нэмэгдэж байгаагаас хүний нөөцийн доголдол үүсч болзошгүй.

# КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА




"Гермес Центр" ХХК нь 2003 онд байгуулагдсан бөгөөд компанийн төв нь нийслэл Улаанбаатар хотноо дэд бүтэц сайн хөгжсөн, А зэрэглэлийн бүсэд нийт 12 000 ам метр талбай бүхий 3 давхар худалдааны төвийн барилгад үйл ажиллагаа явуулж байна. Худалдаа үйлчилгээний төвийн барилга нь оффисийн барилга болох "А" болон худалдаа үйлчилгээний барилга болох "Б" корпусын барилгаас бүрдэнэ.

| УБ хот дахь Гермес худалдааны төвийн орлого | Талбай /кв/м/ | 2007 он (хөндлөнгийн аудит хийлгэсэн) | 2008 он (төсөвлөгдсөнөөр) |
|---|---|---|---|
| Нийт борлуулалтын орлого | 12000 | 701.4 сая төгрөг | 1 125.6 сая төгрөг |
| Цэвэр ашиг | | 383.4 сая төгрөг | 394.0 сая төгрөг |

"Гермес Центр" ХХК нь худалдааны төвийн түрээсийн үйл ажиллагааны зэрэгцээ БНХАУ-ын нэр хүнд бүхий Кипор, Мидеа, Сунинг компаниудын онцгой эрхт албан ёсны борлуулагчийн гэрээгээр гэр ахуйн цахилгаан барааны худалдаа, Дади (Baoding Dadi Automobile Industry Co.,Ltd) автомашины үйлдвэртэй онцгой эрхт албан ёсны борлуулагчийн гэрээгээр автомашины худалдаа, засвар оношилгооны үйлчилгээ явуулдаг. Мөн эдгээр гэрээт компаниудын бараа бүтээгдэхүүнийг Эрдэнэт, Сэлэнгэ, Арвайхээр, Дархан, Сайншанд зэрэг хотуудын салбар дэлгүүрүүдээрээ худалдаалдаг. Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын гишүүн компани юм.

# БИЗНЕСИЙН ТҮНШ

Манай компани хот хөдөөд борлуулалтын өргөн сүлжээ байгуулан хямд үнэ, өндөр чанар, өргөн сонголтыг санал болгох бөгөөд даатгал болон лизингийн үйлчилгээнд бүрэн хамрагдах боломжийг хамтарч ажиллаж буй байгууллагуудтай хийсэн гэрээ, хэлцлийн үр дүнд үйлчлүүлэгч иргэд, байгууллагуудаа олгож байна.

Бидний бизнесийн түнш байгууллагууд: "Голд цикл" ХХК, "Сайн компьютерс" ХХК, "ОХБ" ХХК мөн БНХАУ –ын "Gome" Хувьцаат компани, "Сунинг" корпораци

## МОНГОЛ ШУУДАН БАНК

Монгол Шуудан банктай байгуулсан "Лизингийн Хамтын Ажиллагааны Гэрээ" -ний дагуу Гермес худалдааны төвөөр борлуулах гэр ахуйн болон автомашины санхүүжилтийг худалдан авагч нарт 0 хувийн урьдчилгаа болон 100 хувийн лизингээр олгож байна.

website: www.postbank.mn

## МИГ ДААТГАЛ ХХК

Хоёр байгууллагын хооронд байгуулсан гэрээний дагуу Гермес худалдааны төвөөр борлуулах гэр ахуйн бараа болон автомашиныг эд хөрөнгийн даатгалд нэг жилийн турш 100 хувь хамруулдаг.

website: www.mig.mn

## BAODING DADI AUTOMOBILE INDUSTRY CO., LTD

Тус компани нь Бээжингээс 138 км-т орших БаоДин хотод байрладаг. Pick-up, SUV төрлийн автомашин үйлдвэрлэгч хамгийн том компанид тооцогддог бөгөөд ISO9001 олон улсын чанарын баталгаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Орос, Америк, Зүүн өмнөд Азийн орнууд, Дундад ази зэрэг нийт 40 улсад машинаа борлуулдаг бөгөөд жилд нийт 50 000 ширхэг машин үйлдвэрлэх хүчин чадалтайгаар ажилладаг.

website www.bddqc.com.cn

## MIDEA GROUP

Midea Group нь 1968 онд байгуулагдсан бөгөөд Хятадын хамгийн том электрон бараа үйлдвэрлэгчдийн нэг юм. Одоогоор 70 000 гаруй харилцагчидтай бөгөөд дэлхийд 12 төрлийн бүтээгдэхүүнээрээ алдартай юм. Гол бүтээгдэхүүнүүд нь: агааржуулагч, цахилгаан зуух, угаалгын машин, цахилгаан халаагуур, аяга таваг угаагч, тоос сорогч гэх мэт гэр ахуйн цахилгаан бараанууд.

website www.midea.com.cn,

## WUXI KIPOR POWER CO.,LTD

KIPOR GROUP нь анх "KAMA" нэртэйгээр 1998 байгуулагдсан бөгөөд дижитал зөөврийн цахилгаан үүсгүүр, зөөврийн усны насос, дуу чимээ бага дижитал генератор, гэрэлтүүлэгч цамхагууд гэх мэт өндөр чанартай бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэдэг. Импортлох бүтээгдэхүүн: Дижитал зөөврийн цахилгаан үүсгүүр, Зөөврийн усны насос, дуу чимээ бага дижитал генератор, гэрэлтүүлэгч цамхагууд.

website www.kipor.com

# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2008.01.01-ний байдлаар 7.12 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, 2007 оны жилийн эцсийн байдлаар борлуулалтын орлого 660 сая төгрөгд хүрч, 383,3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилсан байна.

Компани анх үүсгэн байгууллагдаж байх үед худалдааны төвийн барилгыг барих зориулалттайгаар 2.2 тэрбум төгрөгийн зээл авч, 2007 онд 1.2 тэрбум төгрөгийн үндсэн өр ба хүүг буцаан төлж, 2008 оны эхний хагас жилд багтаан үлдэгдэл 1 тэрбум төгрөгийн урт хугацаат зээлийг саадгүй төлөх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа болно. Нийт хөрөнгөд эзлэх өрийн харьцаа 22 хувь болно.

*Санхүүгийн тайлангуудад "Иттэлт-Аудит" компани аудит хийсэн болно.*

**Үлдэгдлийн тэнцэл** /мянган төгрөгөөр/

| Хөрөнгө | **2007-12-31** | **2008-03-31** |
|---|---|---|
| Эргэлтийн хөрөнгө | 408,320.7 | 437,938.8 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 6,717,081.8 | 6,676,358.5 |
| Нийт хөрөнгө | 7,125,402.5 | 7,114,297.2 |
| Эх үүсвэр | | |
| Нийт өр төлбөр | 1,627,392.3 | 1,581,270.1 |
| Эзэмшигчийн өмч | 5,498,010.1 | 5,533,027.1 |
| Нийт эх үүсвэр | 7,125,402.5 | 7,114,297.2 |

**Орлого үр дүнгийн тайлан**

| | **2007-12-31** | **2008-03-31** |
|---|---|---|
| Нийт борлуулалт | 701,436.4 | 188,576,1 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 37,479.0 | - |
| Нийт ашиг | | |
| Үйл ажиллагааны зардал | 552,822.4 | 145,152.1 |
| Үйл ажиллагааны ашиг/алдагдал | 111,135.0 | |
| Үйл ажиллагааны бус ашиг/алдагдал | | 43,424.1 |
| Татварын өмнөх ашиг | 428,643.8 | 38,930.0 |
| Орлогын татвар | 45,282.2 | 3,913.0 |
| Цэвэр ашиг | 383,361.6 | 35,017.0 |

# ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

**"Гермес Центр" компани нь 3-н хувь нийлүүлэгчтэй.**

| **Нэр** | **Албан тушаал** | **Мэргэжил** | **Төгссөн сургууль** |
|---|---|---|---|
| Д. Зоригт | ТУЗ-ийн дарга | Инженер-эдийн засагч | ЗХУ-ын Ростов хотын Дээд сургууль |
| М. Түмэнжаргал | ТУЗ-ийн гишүүн | Эдийн засагч | ЗХУ-ын Одесса хотын Дээд сургууль |
| Т. Гансүлд | ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал | Эдийн засагч | СЭЗДСургууль, АНУ-ын Жон Кеннедийн Их Сургууль |



## Гүйцэтгэх удирдлага

Түмэнтөр овогтой Гансүлд тус компанийн Гүйцэтгэх захирлын албыг 2007 оноос хашиж буй. Улаанбаатар хотноо 1972 онд төрсөн. Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуулийг 2000 онд Эдийн засагч мэргэжлээр дүүргэсэн. 2004-өөс 2006 онд АНУ-ын John F. Kennedy University-г Бизнесийн Удирдлагын Магистр, Стратеги Удирдлага чиглэлээр дүүргэсэн. 2006-аас 2007 онд АНУ-ын Калифорни муж, Плезантон хотноо байрлах Morgan Stanley Dean Witter хөрөнгө оруулалтын банкинд ажилласан.

## Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл

| | **Энгийн хувьцаа эзэмшигчийн нэр** | **Хувьцааны тоо ширхэг** | **Нийт хувьцааны дунд эзлэх хувь** |
|---|---|---|---|
| 1 | Д.Зоригт | 31 338 657 | 39.9% |
| 2 | М.Түмэнжаргал | 20 892 438 | 26.6% |
| 3 | Т.Гансүлд | 2 749 006 | 3.5% |
| 4 | Нэмж орох шинэ хувьцаа эзэмшигчид (Анхдагч хөрөнгийн зах зээлийн арилжааны үр дүнд) | 23 562 900 | 30% |
| | **Бүгд** | **78,543,001** | **100%** |

# КОМПАНИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



# ТӨСЛИЙН САНХҮҮГИЙН ТААМАГЛАЛ

**Санхүүгийн таамаглал** /мянган төгрөг/

| **Орлого** | **2008** | **2009** | **2010** | **2011** | **2012** |
|---|---|---|---|---|---|
| Жилийн дундаж өсөлт | 5% | 7% | 7% | 7% | 7% |
| Түрээсийн орлого | 900 000 | 1 683 000 | 1 800 810 | 1 926 867 | 2 061 747 |
| УБ хотын борлуулалт | 500 000 | 525 000 | 551 250 | 578 813 | 607 753 |
| Автомашин борлуулалт | 1 500 000 | 1 637 500 | 1 820 000 | 2 025 000 | 2 025 000 |
| Орон нутгийн борлуулалт | 381 400 | 408 000 | 408 000 | 408 000 | 408 000 |
| НӨАТ | 328 140 | 425 350 | 458 006 | 493 868 | 510 250 |
| **Нийт борлуулалт** | 3 609 540 | 4 678 850 | 5 038 066 | 5 432 547 | 5 612 751 |
| ББӨ | 1 626 678 | 1 592 195 | 1 725 836 | 1 875 916 | 1 867 178 |
| **Нийт ашиг** | 1 982 862 | 3 086 655 | 3 312 230 | 3 556 631 | 3 745 573 |
| **Зардал** | 810 329 | 985 238 | 1 049 011 | 1 118 696 | 1 119 642 |
| Үйл ажиллагааны зардал | 582 210 | 806 325 | 867 090 | 933 489 | 971 550 |
| Элэгдэлийн зардал | 80 000 | 80 000 | 80 000 | 80 000 | 80 000 |
| Зээлийн хүүний зардал | 105 300 | 39 000 | 39 000 | 39 000 | - |
| НДШ зардал | 49 779 | 68 941 | 74 136 | 79 813 | 83 068 |
| ҮХХАТ | 14 000 | 20 000 | 20 000 | 20 000 | 14 000 |
| **Татварын өмнөх ашиг** | 1 151 573 | 2 072 389 | 2 232 004 | 2 404 329 | 2 694 023 |
| ААНБОАТ 10% | 115 157 | 207 239 | 223 200 | 240 433 | 269 402 |
| **Цэвэр ашиг** | **972 637** | **1 776 210** | **2 914 667** | **2 064 083** | **2 327 553** |

# ГЕРМЕС ЦЕНТР ХК-ИЙН 2007 ОНЫ ЦЭВЭР АШИГ БОЛОН ИРЭХ ЖИЛҮҮДИЙН ЦЭВЭР АШГИЙН ТААМАГЛАЛ



# ХУВЬЦААНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН ТААМАГЛАЛ

"Гермес центр" ХК-ийн нэгж хувьцааны зах зээлийн төсөвлөгдсөн үнэ (төгрөг)




# НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ БОДЛОГО

2008 оноос эхлэн "Гермес Центер" компани нь жилийн эцсийн цэвэр ашгийн 30%-ийг ногдол ашигт хуваарилж, үлдэх 70%-ийг компанийг цаашид хөгжүүлэх урт хугацааны стратеги төлөвлөгөөний дагуу зорилтот төслүүдийг санхүүжүүлэх бодлоготой ажиллана.

Нэгж хувьцааны EPS, P/E харьцаанууд төлөвлөсөн 4 жилд дараах байдалтай байна.



# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БОЛОН МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБООНЫ ГИШҮҮН АНДЕРРАЙТЕР БРОКЕР ДИЛЕРИЙН

## "БАТС ИНВЕСТ" ХХК

Зорилго: Хөрөнгийн зах зээлд харилцагчдаа дээдэлсэн, иж бүрэн үйлчилгээ үзүүлэх.

"Батс Инвест" ХХК нь 1997 онд байгуулагдан Монгол улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж ирсэн.

**Үйл ажиллагааны чиглэл:**

*Андеррайтерийн үйл ажиллагаа:* 2007.08.17-ны өдрийн 111 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлд Андеррайтерийн үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жилийн хугацаатай авсан. Анхдагч зах зээлд үнэт цаас гаргах болон нэмж гаргахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг цогцоор нь хийж гүйцэтгэх.

*Брокерийн үйл ажиллагаа:* Харилцагч гадаад дотоодын иргэд байгууллагуудад Бонд болон хувьцаа худалдах, худалдан авахад зуучлах.

Хөрөнгийн зах зээлийн талаар мэдээ, зөвөлгөө өгөх: Үнэт цаасны зах зээлд үйлчилж буй хууль тогтоомж, дүрэм журам, зохицуулагч болон оролцогч байгууллагуудын талаарх мэдээлэл, үнэ ханш болон хэтийн талаар хамгийн сүүлийн үеийн мэдээллийг өгөх.

**Туршлага:**

- Тус зах зээлд мэргэшсэн, мэргэжлийн боловсон хүчинтэй.
- 1997 оноос одоог хүртэл хөрөнгийн зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа явуулж ирсэн.
- 2008/03 сард Монинжбар ХК –ийн "Бүтээн байгуулалт" бондын Ерөнхий зуучлан борлуулагчаар ажилласан
- 2008/04 сард "Гермес" ХХК –ийг нэмж хувьцаа гаргах замаар нийтэд нээлттэй ХК болгон өөрчлөн байгуулах төслийг хэрэгжүүлэн, ерөнхий зуучлан борлуулагчаар ажиллаж байгаа.

**Бидэнтэй харилцах**

Хаяг: УБ, СБД, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Үнэн сонины байр, 202 тоот
Утас: 321 899, 323 199,
Факс: (976-11) 322 770
E-mail: info@batsinvest.mn

# Уг төсөлд хамтарч ажилласан мэргэжлийн байгууллагууд:

## Ерөнхий зуучлан борлуулагч

**Батс-Инвест ХХК**
СЗХ-ны 3/13 тоот тусгай зөвшөөрөлтэй.
Хаяг: УБ, СБД, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Үнэн сонины байр, 202 тоот
Утас: 321 899, 323 199,
Факс: (976-11) 322 770
E-mail: info@batsinvest.mn

## Бизнесийн үнэлгээ

**Итгэлт-Аудит ХХК**
Монгол Улсын Сангийн яамны 03 тоот тусгай зөвшөөрөлтэй.
Үнэлгээчин Г.Баянмөнх. Хөрөнгийн үнэлгээ хийх 07120001 тоот гэрчилгээтэй.
Хаяг: ХААЯ-ны ард ХХААХоршоологчдын байр 2-р давхар.
Утас: 451150,
Факс: (976-11) 451150,

## Хөрөнгийн үнэлгээ

**Хөрөнгийн үнэлгээний төв ХХК**
Хөрөнгийн үнэлгээ хийх 04 тоот тусгай зөвшөөрөлтэй.
Үнэлгээчин Л.Оюунзул. Бизнесийн үнэлгээ хийх 62 тоот тусгай зөвшөөрөл, Хөрөнгийн үнэлгээ хийх 071200019 тоот гэрчилгээтэй
Хаяг: ЧД, 3-р хороо, Санбуутийн гудамж-11, Застийг газрын 11-р байр.
Утас: 325127,
Факс: (976-11) 325175

## Хөрөнгийн үнэлгээ

**Лэндс ХХК**
Хөрөнгийн үнэлгээ хийх 07 тоот тусгай зөвшөөрөлтэй.
Үнэлгээчин Ж.Энхчимэг. Хөрөнгийн үнэлгээ хийх 071200053 тоот гэрчилгээтэй.
Утас: 99116570, 330376,
Факс: (976-11) 330376,
E-мэйл: ganhuyag_9@yahoo.com